

2010

СЭЗДС

IFE

Г.Гантулга

Ч.Өнөржаргал



[НӨАТ-ЫН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭНД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДЛУУД]

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: ОРШИЛ БА СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Татвар бол улсын эдийн засаг нийгмийг өгжүүлэх талаар тавьж буй нийтлэг зорилтыг хэрэгжүүлэх төрийн аппаратыг зохих түвшинд ажиллуулахад шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх үндсэн хэлбэр билээ. Эдийн засагт татварын механизмын үзүүлэх нөлөө түүнийг хэрхэн яаж ашиглах зэргийг судлах нь ихээхэн ач холбогдолтой. НӨАТ нь Нэмэгдсэн өртгийн албан татвар нь төсвийн уян хатан маш тогтвортой эх үүсвэр болдогоос гадна татварын тогтолцоог боловсронгуй болгоход ихээнхэн ач холбогдолтой юм. Нэмэгдсэн өртгийн албан татвар манай улсад хэрэгжээд удаагүй ч онол болон судалгааны ажил бусад олон улсын туршлагыг хуримтлуулах дээр үндэслэн бэлтгэгдсэн боловч төгс боловсронгуй болж чадаагүй байгаа татварын төрөл юм.

Нэмэгдсэн өртгийн албан татвар нь эцсийн дүндээ аливаа улс орны хүн ам, аж ахуйн нэгж, байгууллагуудыг нэг буюу энэв санхүүгийн тайлан мэдээлэл бэлтгэдэг болгох, татварын өндлөнгийн мэдээллийг цуглуулах найдвартай хэрэгсэл, эхүүсвэр болох ингэснээр далд эдийн засаг буюу хар зах зээлийг багасгах, улмаар арилгах, мөнгөний урсгалыг төр өөрийн хяналтад байлгаж, хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагыг санхүүгийн цэгцтэй тогтолцоонд оруулах ач холбогдолт бүхий татвар юм. Иймээс бид энэхүү чухал ач холбогдолтой татварын зүйл Монголд хэрхэн хэрэгжиж байгаа болон цаашид авч хэрэгжүүлэх санал дүгнэлт боловсруулах зорилгоор энэхүү сэдвийг сонгож авч судалгаа хийж байна. НӨАТ-ийн тухай, үүнийг хэрэгжүүлэхэд авч хэрэгжүүлэх санал дүгнэлт боловсруулна гэвэл зайлшгүй татварын механизмыг авч үзэх шаардлагатай юм. Татварын механизм гэдэг нь татварын бодлогыг хэрэгжүүлэх үүднээс төрөөс түүний тогтолцооны хүрээнд авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны цогц юм.

ХОЁРДУГААР ХЭСЭГ: СУДАЛГААНЫ ХЭСЭГ

2.1. Онолын судалгаа

Нэмэгдсэн өртгийн албан татвар бол хувь хүнд шууд ногддоггүй харин тухайн хүнд үйлчилсэн үйлчилгээ ба бараанд ногдуулсан шууд бус хэлбэрийн татвар гэж олон улсын практикт өргөн хэрэглэх болжээ. Өөрөөр хэлбэл эцсийн үр дүн гарахыг хүлээхгүйгээр

борлуулалт, бараа, ажүйлчилгээнд ногдуулан авдаг учраас төсвийн орлогын найдвартай эх үүсвэр болдог гэж үздэг.

20-р зууны сүүлчээр санхүүгийн салбарт гарсан томоохон ололтуудын нэг нь нэмэгдсэн өртгийн албан татварыг нэвтрүүлсэн явдал гэж үздэг бөгөөд татварын эрх зүйн хөгжлийн олон зууны үүхэнд НӨАТ нь шууд бус татвар ногдуулалтын харьцангуй шинэ төрөл болон гарч ирсэн.

Нэмэгдсэн өртгийн албан татварыг анх 1920 онд Германы бизнесмен Вон Сименс бичиж тэмдэглэсэн гэдэг. НӨАТ-ыг санаачлан нэвтрүүлсэн анхны орон бол Франц улс юм. Энэ татварын үндэс нь гүйлгээний татварыг суутгах, хэрэглэх тогтолцооны хөгжлийн дараалсан гурван үе шатанд оршдог. НӨАТ-ын хөгжлийн үе шатыг

- 1937 он, гүйлгээний татвараас үйлдвэрлэлийн нэгдсэн нэг татварт шилжсэн шилжилт
- 1948 он, саланги өлбөрийн системийг бий болгосон /Энэ тогтолцооны дагуу үйлдвэрлэгч татварыг хасаж уг зөрүүгээр сард нэг удаа татвар төлдөг байв/
- 1954 он, НӨАТ-ыг татварын практикт нэвтрүүлсэн гэсэн гурван үе шатаар авч үздэг.¹

Онолын хувьд НӨАТ нь эцсийн хэрэглэгчид ногдох ёстой байдаг боловч түүнийг эцсийн хэрэглээнээс өмнө буюу эцсийн хэрэглээний өмнөх үйлдвэрлэл, хувиарлалтын шатанд ч авч болдог. Өөрөөр хэлвэл НӨАТ -ын нэг болон олон шатлалт хэлбэрд байдаг ба эдгээрээс алиныг нь ч сонгосон гэсэн эцсийн хэрэглээнд ногдох татварын дарамт төвийг сахисан, олон нийтэд ил тод байх шаардлагыг хангасан байх шаардлагатай.

Нэг шатлалтай НӨАТ-ыг эцсийн хэрэглэгч бараа, үйлчилгээг худалдан авч буй тэр үед авдаг. Нэг шатлалтай хэрэглээний татварыг үйлдвэрлэл, хувиарлалтын эхний шатуудад авах нь татварын шатлал болон эцсийн хэрэглээний хоорондох нэмү өртөг, шатлалын тоо зэргээс хамаарч тухайн барааүйлчилгээний үнийн тодорхой хувьд нөлөөлдөг . Энэ нь төвийг сахисан, олон нийтэд ил тод байдал алдагдахад хүргэх талтай.

¹ http://revolution.allbest.ru/finance/00040255_0.html

Харин олон шатлалт НӨАТ-ын 2 хэлбэр байдаг ба тухайлбал татварыг үйлдвэрлэл, хуваарилалтын тухайн үе шат бүрт ногдуулснаар бараа үйлчилгээний өртгийн нэг хэсэг болдог ба ингэснээр дараагийн шатанд ногдох хэрэглээний татварын сууринд багтан ордог. Харин НӨАТ -ыг ингэж тооцох нь үүний төвийг сахисан, олон нийтэд ил тод байх явдлыг алдагдуулдаг.ӨАТН -ын хуримтлагдаагүй хэлбэр нь үйлдвэрлэл хувиарлалтын үе шат бүрт уг татварыг ногдуулж, дараагийн шатанд түүнийг нь бүрэн тэглэх замаар эцсийн хэрэглээнд ногдох хүртэл явагддаг.

НӨАТ нь урд хэрэглэж байсан гүйлгээний татвараас татварын давхардал гаргадаггүйгээрээ давуу бөгөөд экспортод гаргаж байгаа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд өмнөх шатанд төлсөн татвар болон дотоодоос худалдан авсан бараа, ажилүйлчилгээнд ногдуулсан татварын хасалт хийж буцаан олгодог бөгөөд импортод ногдуулж байгаа татвар, дотоодын бараа, ажилүйлчилгээнд ногдуулж байгаа татвар нь нэгэн адил хувь хэмжээтэй байдгаараа илүү талтай юм.

НӨАТ нь шууд бус хэрэглээний татвар тул эцсийн хэрэглэгч энэ татварын төлөгч болохоос бус импортлогчүйлдвэрлэгч, худалдаа эрхлэгчдэд төдийлөн нэмэлт дарамт болдоггүй. Харин бараа, үйлчилгээ нь тодорхой хэмжээгээр нэмэгдэж, зах зээлийн өрсөлдөөнд нөлөөлөх талтай.

Татварын тогтолцоонд шийдвэрлэвэл зохих олон асуудлыг шийдэхдсэн арга зам нь бодлого оновчтой, хэрэгжих боломжтой байхад оршино. Татварын бодлого улс орны өөрөө өөрийгөө нөхөн хангах чадвартай, эдийн засгийн тогтвортой хөгжлийн стратегид хүрэхтэй уялдан харилцаанд оролцогч талуудын амьдрах чадвартөргөөр нөлөөлөхгүй байх үвшинд боловсрогдох учиртай. Иймээс татварын бодлогод татвар цуглуулах баазыг бүрдүүлэх, хувь хэмжээг оновчтой тогтоохоос гадна хуулийг хэрэгжүүлэх удирдлага, механизмыг ч орхигдуулахгүйгээр цогцоор авч шийдвэрлэх нь улс орны хөгжилд тустай.

Татварын бодлогын стратегийг эрдэмтэн судлаачид дараах байдлаар тодорхойлсон байдаг.

- ✓ Татварын бүтэц нь нийгэм эдийн засгийн бүтэцтэйгээ нийцсэн байх,
- ✓ Татвар ногдуулах бааз суурь өргөн байх,
- ✓ Татвар ногдуулах хувь хэмжээ оновчтой байх,

- ✓ Ядуу хэсгийн татварын ачаалал бага байх.

Татварын бодлогод нөлөөлөх хүчин зүйлс:

- ✓ Гадаад хүчин зүйлс:
 - Улс төрийн хүчин зүйлс: Төр, улс төрийн намуудын бодлого, эрх зүйн орчин, гадаад харилцаа
 - Эдийн засгийн хүчин зүйлс: Эдийн засгийн бүтэц, өсөлт
 - Нийгмийн хүчин зүйлс: Татварын харилцаанд орж буй талуудыг татварт хандах хандлага, төлөвшил
 - Мэдээлэл, технологийн хүчин зүйлс: Мэдээлэл, хяналт, бүртгэлийн орчны зохион байгуулалт, төлөвшил, хангамж
- ✓ Дотоод хүчин зүйлс:
 - Татвар ногдуулах, хураахйл ажиллагаа болон төрийн албаны бүтэц, зохион байгуулалт
 - Ажиллах хүчний нөөц, хүний хүчин зүйлийн бодлого
 - Татварын албаны үйл ажиллагаа
 - Татварын механизмын үйлчлэл

НӨАТ тогтоосон бүх орнуудын ерөнхий чиг хандлагаас харвал энэ төрлийн татварыг татварын тогтолцоон дахь нэг голлох татвар болгон хувиргасанд оршино шалтгаан нь НӨАТ:

- ✓ Төсвийн орлогын найдвартай эх үүсвэр болдог;
- ✓ Татвар хураахад хялбар учир татварын тогтолцоог гажуудуулах нь бага;
- ✓ Татварын хяналт шалгалт хийх нөхцлийг бүрдүүлдэг;
- ✓ Олон улсын нийтлэг, стандарт загвартай тул олон улсын жишигт нийцсэн татварын тогтолцоог үрдүүлэхэд хялбар зэрэг давуу талуудыг олгодогтой холбогдоно.

Дутагдалтай тал нь:

- ✓ Татварын шударга байх, өлөгдөхүйц байх зарчмуудтай зөрчилдөх /хэрэглээгээр дамжин ногдуулдаг учир татварын төлбөрийн чадвартай уялдаж

чаддаггүйгээс нийгмийн орлого багатай, ядуу хэсэгт татварын дарамтыг үүсгэн, шударга бус тогтолцоо бүрдэнэ/;

- ✓ Орлого хуваарилалтанд өрөг нөлөөтэй /бага орлоготой өрхийн хувьд НӨАТ нь хэрэглээгээр дамжин төлдөг учир зайлшгүй бодит хэрэглээгээ бууруулахаас өөр аргагүй болдог нь тэдний амьжиргааны түвшинд сөргөөр нөлөөлнө гэсэн талаас авч үзнэ./

2.2. НӨАТ-ын хэрэгжилтийн өнөөгийн байдал

Өнөөгийн байдлаар дэлхийн 123 оронд хэрэгжиж, энэ татвар нь жил бүр дунджаар татварын орлогын 27 хувь буюу дотоодын нийт бүтээгдэхүүний /ДНБ/ 5 орчим хувьтай тэнцэх хэмжээний орлогыг бүрдүүлж байна. Энэхүү үзүүлэлт манай орны хувьд харьцангуй бага буюу 2-3 хувь байдаг ба сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байгаа юм. Ингэж өсөж байгаа шалтгаан нь дотоодын нийтүтбэгдэхүүнд хувь нэмрээ оруулж байгаа компаниудын борлуулалтын хэмжээсөж 10 саяын босгыг давах болсонтой холбоотой. Доорх хүснэгнэлд ДНБ-д эзлэх НӨАТ-ийн хувь хэмжээг харууллаа.

Хүснэгт 1. ДНБ ба НӨАТ-ын харьцаа /сая.төг/

Орлогын төрөл	2006 он	2007 он	2008 он	2009 он
ДНБ	3 017 425.8	3 325 892.5	3622 670.5	3564278.1
Үүнээс: НӨАТ	87,892,4	94,158,3	138,788,4	157,992,3
НӨАТ/ДНБ%	2,9%	2,8%	3,8%	4,4%

Дэлхийн олон орнуудад НӨАТ-ыг татварын нэгэн төрөл болгон хэрэглэж байгаа ба төсвийн орлогод голлох үүргийг гүйцэтгэдэг. Энэ татвар нь 3 хувилбартай байдаг. Үүнд:

- ✓ Үйлдвэрлэлийн төрлийн НӨАТ (Value added tax)
- ✓ Орлогын төрлийн НӨАТ (Sales tax)
- ✓ Хэрэглээний төрлийн НӨАТ (Consumption tax)

Монгол Улсын хувьд Үйлдвэрлэлийн төрлийн буюу олон улсад Нэмэгдсэн өртгийн албан татвар гэж нэрлэгддэг үйлдвэрлэлийн шат бүрд ногдуулдаг буюу **олон шатлалт** хэлбэрээр энэхүү татварыг хэрэгжүүлж байна. Дараах хүснэгтэнд Монгол Улсын татварын нийт орлогыг сүүлийн 9 жилийн байдлаар харуулсан ба нийт татварын орлогод шууд ба шууд бус татварын эзлэх хувь хэмжээ харууллаа. Эндээс харвал нийт татварын

орлогод эзлэх хэвь хэмжээ жилээс жил буурсаар байна. Энэ нь сүүлийн жилүүдэд уул уурхай зэрэг дотооддоо хэрэглэйд ггадаадад гаргадаг бүтээгдэхүүн нэмэгдэж байгаатай холбоотой юм. Учир нь экспортод НӨАТ-ын 0 хувь хэмжээг хэрэглэдэг билээ. Цаашид ч уул уурхайн салбарын эрчимтэй өсөлттэй холбоотойгоор шууд бус татварууд тэр дундаа НӨАТ-ийн татварын орлогод эзлэх хувь хэмжээ буурах магадлалтай байна. Ингэснээр дээрх дурдсанчлан НӨАТ-ын нэг давуу тал бол төсвийн орлогын найдвартай эх үүсвэр болох ингэснээр далд эдийн засаг буюу хар зах зээлийг багасгах, улмаар арилгах, мөнгөний урсгалыг төр өөрийн хяналтад байлгах зэрэг эерэг нөлөөллүүд буурах хандлагатай болох юм. Манай орны нийт экспортын дийлэнх буюу бараг 90 орчим хувийг уул уурхайн бүтээгдэхүүн эзлэж байгаа ба бараг үүхий чигээрх нь буюу боловсруулалт хийлгүйгээр буюу өртөг нэмэгдүүлэлгүйгээр шууд гаргаж байгаа энэүед “Нэмэгдсэн өртгийн” Албан татвараас “чөлөөлж” байгаа нь учир дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл бид баялагыг өртөггүйгээр /“өртөггүйжүүлж”/ байна гэж шууд ойлгогдохоор байна. Манайх шиг дан уул уурхайгаас хараат улсын хувьд уул уурхайн салбарт арай өөр зарчмаар НӨАТ ноогдуулах /бусад улсаас “хуулахгүйгээр”/ тухайлбал худалдан авалтанд өлсөн өн НӨАТ-ыг буцаан олгох өөрөөр хэлбэл өлөөлөгдөх үйлдвэрлэл үйлчилгээнд хамруулах нь шударга байдалд нийцэх болой. Энэ нь тэд баялагыг минь худалдан авахад өлсөн “өртөг” хэмээн үзэх ёстой хэмээн бодож байна. Судалгаанаас үзэхэд өндөр хөгжилтэй ихэнх улс экспортоо НӨАТ-аас чөлөөлөх ба “0” хувь хэмжээ хэрэглэдэг ба гэхдээ тэдний эдийн засгийн бүтэц нь экспортод чиглэсэн ба гадагш гаргаж байгаа бараа үйлчилгээнүүд нь ихэвчлэн дахин нэмүү өртөг бий болгох боломжгүй буюу эцсийн бүтээгдэхүүн үйлчилгээ байгаа нь манай орноос эрс өөр байгаа юм.

Хүснэгт 2. Татварын орлогын хэмжээ тэдгээрт татварын төрлүүдийн эзлэх хувь

	2001 ОН	2002 ОН	2003 ОН	2004 ОН	2005 ОН	2006 ОН	2007 ОН	2008 ОН	2009 ОН
Нийт: үүнээс	138,906	186,642	183,623	286,081	290,319	719,849	933,563	1,044,098	920,417
Шууд татвар	39%	37%	36%	40%	40%	41%	53%	54%	56%
Шууд бус татвар	61%	63%	64%	60%	60%	59%	47%	46%	44%
Үүнээс НӨАТ	30.1%	22.4%	26.1%	20.2%	24.2%	12.2%	10.1%	13.3%	17.2%

Нийт татвар төлөгч аж ахуйн нэгжүүдийн дийлэнх хувь нь жижиг бизнес эрхлэдэг нь дараах тоо мэдээнээс харагдаж байна. Үүнд нийт татвар төлөгчдийн хувь нь буюу 30700

нь 10 саяөгрөгөөс доош борлуулалт хийдэг гэсэн дүн гарсан нь бодит байдалд нийцэхгүй баөйна гэжүзэж байна. 10 сая төгрөгийн орлогогүй аж ахуйн нэгж оршин тогтноход хэцүү гэдгийг энгийн логик батална. Жишээгээр авч үзье. Нэг орон тоотой аж ахуйн нэгж жилд цалингийн зардлаа олохын тулд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр бодвол жил нийт 1296,000 төгрөг /108000*1*12/, нэмэх нь НДШ 129,600 төгрөг, нийт хамгийн багадаа 1425,600 өгрөг шаардлагатай. Бизнесийн өгөөжийн түвшин хамгийн багаар бодоход жилийн 12 хувь гэвэлөвхөн цалинд олгох мөнгөө олохын тулд ядаж 11880,000 өгрөгийн орлого олох шаардлагатай байгаа юм. Иймээс НӨАТ төлөгчөөр бүртгээгдээгүй ААНБ-ийн тоо хэмнэдэслэлгүй байгаа юм. Энэ НӨАТ-ын хяналт сул байгаа, хариуцлага бараг байггүй холбоотой. Үүнийг засаж залруулахын тулд хяналтыг сайжруулах, ялангуяа НӨАТ -ыг эцсийн дүнд төлж байгаа иргэдийн оролцоо, хяналтыг сайжруулах шаардлагатай байнагЖингү зарим улс орнуудад нэн зорилгоор жилийн эцэст эцсийн хэрэглэгчид татварынх нь тодорхой хэсгийн буцаан олгох систем хэрэглэж байгаа туршлагыгүлэжнэвтр шаардлагатай юм.

Хүснэгт 3. НӨАТ төлөгчдийн тоо, борлуулалтын орлого

Борлуулалтын орлого	Татвар төлөгчдийн тоо	Борлуулалтын орлого /мян.төг/	НӨАТ төлөгчөөр бүртгэгдсэн татвар төлөгчдийн тоо	НӨАТ төлөгчдийн борлуулалтын орлого /мян.төг/
0-10 сая төгрөг	30700	61,487,635.8	1633	3,915,247.9
10-15 сая төгрөг	1486	18,282,854.1	476	6,005,014.1
15-20 сая төгрөг	1018	17,724,265.7	468	8,219,815.1
20-50 сая төгрөг	3025	98,646,605.4	1738	57,332,800.7
50-75 сая төгрөг	1186	72,947,367.3	766	47,180,027.9
75-100 сая төгрөг	777	67,549,668.5	560	48,717,879.3
100 саяаас дээш төгрөг	4359	10,275,693,754.8	3558	9,100,907,756.4
Нийт	42551	10,612,332,151.6	9199	9,272,278,541.4

Өмнөх онолын судалгааны хэсэггүйлсэнчлэн татварыг бодлого дараах зүйлсэд чиглэгдэх шаардлагатай. Үүнд:

- ✓ Татварын бүтэц нь нийгэм эдийн засгийн бүтэцтэйгээ нийцсэн байх,
- ✓ Татвар ногдуулах бааз суурь өргөн байх,
- ✓ Татвар ногдуулах хувь хэмжээ оновчтой байх,
- ✓ Ядуу хэсгийн татварын ачаалал бага байх.

Дээрх шаардлагуудад нийцсэн татварын бодлого баримталж буй улс орнуудад А.Смитийн тодорхойлсон татварын үндсэн зарчмууд хангагддаг гэж үзэж болно. Уг үндсэн зарчмууд нь:

1. Тэгш шударга байх.
2. Төлөгдөх боломжтой байх.
3. Энгийн ойлгомжтой, мөрдөхөд хялбар байх зэрэг зарчмууд болно.
4. Үр ашигтай байх.

Гэтэл манай улсад одоо хэрэгжүүлж буй НӨАТ нь дээрх 4 зарчмыг аль алиныг нь зөрчсөн гэдэг дүгнэлтийг өгч болно. Энэ дүгнэлтийг ямар нэгэн санал асуулга, тоон мэдээ сэлтээр нотлох гэж цаг зав гарздахгүйгээр өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн хүрээнд тайлбарлаж болно. Эдгээрийг дараах байдлаар тус тусад нь тайлбарлан харуулья.

Тэгш шударга байдал:

Энэ нь татвар төлөгчдөд ямар нэгэн ялгаатай боломж эсвэл хүндрэл үүсгэх байдлыг бий болгохгүй бүх татвар төлөгч ижил эрх, ижил үүрэгтэйгээр татварын харилцаанд оролцох боломж бүрдүүлэхийг хэлнэ. Улс орны нийгэм, эдийн засгийн байдалд ихээхэн ач холбогдолтой, ирээдүйд хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай салбарыг л дэмжсэн бодлого чвагдах ёстой. Манай улсын хуулинд татварын “0” хувь, татвар төлөх тухай заалтуудаар уг асуудал нотлогдоно. Тухайлбал:

НӨАТ-ыг “0” хувиар ногдуулах заалт:

- ✓ Экспортод гаргасан уул уурхайн эцсийн бүтээгдэхүүн. /Энэ заалтыг 2009 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/

НӨАТ-аас чөлөөлөгдөх бараа:

- ✓ Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах талаар Засгийн газартай байгуулсан гэрээний дагуу газрын тос хайх, олборлох, ашиглах үйл ажиллагаанд зориулан импортлолсон техник, тоног өжөөрөмж, материал, түүхий эд, сэлбэг хэрэгсэл, автобензин, дизелийн түлш;
- ✓ Борлуулсан алт;
- ✓ Борлуулсан сонин.
- ✓ Экспортод гаргасан эцсийн бүтээгдэхүүнээс бусад уул уурхайн бүтээгдэхүүн.

Дэлхийн бусад улс орнуудад үндийн хувцас, ном зэрэг бараануудыг НӨАТ -аас чөлөөлж, өргөн хэрэглээний буюу амьдралын наад захын хэрэглээний зүйлсэд хөнгөлсөн хувь хэмжээгээр татвар ногдуулдаг байна.

Төлөгдөх боломжтой байх:

Манай улсад далд эдийн засгийн хэмжээ их, татвараас зугтаах байдал арилахгүй байгаа гэдэг нь НӨАТ-ын асуудал дээр улам тод харагдаж байна. Үүнийг нотлоход өргөн олныг хамарсан том судалгаа хийх шаардлага бөгөөд хамгийн энгийнээр орон сууцны байрны үүдэнд байрладаг гэр бүлийн жижиг дэлгүүрийн орлогыг баримжаагаар хамгийн багаар жишээ болгон авч үзэхэд шууд харагдаж байна.

Хүснэгт 4. Жижиг хүнсний дэлгүүрийн орлогын судалгаа

Д/д	Барааны нэр	Нэг бүрийн үнэ /дунджаар/	Өдөрт худалдах тоо, хэмжээ	Нийт үнэ /төгрөгөөр/
1.	Сүү/1л/	1500	5ш	7500
2.	Тараг/1л/	1400	5л	7000
3.	Талх	900	10ш	9000
4.	Боов/1кг/	2000	2ш	4000
5.	Чихэр/уутгай/	800	1ш	800
6.	Печень	600	5ш	3000
7.	Давс	200	2	400
8.	Ундаа /Мульти, Гоё гв	600	5	3000
9.	Ус	200	2	400
10.	Ариун цэвэр, ахуйн хэрэглээний зүйлс			5000
11.	Тамхи/Хайрцаг/	1500	1	1500

12.				
13.	Дүн /Өдрийн орлого/			41600
14.	Сарын орлого			1248000
15.	Жилийн орлого			14976000

Хэрвээ борлуулалтын орлогоо үнэн зөвөөр мэдүүлээд, татвараа төлөх боломжтой байсан бол иргэд, ААН-үүд татвар төлөгч болохоос тэглээ их зугтаахгүй байсан.

Энгийн ойлгомжтой, мөрдөхөд хялбар байх:


Дээрх жишээнээс харахад 8 нэрийн үнсний барааны дэлгүүр ажиллуудаг компани бүү хэл дунд зэргийн “ҮЦ” л НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх ёстой болж таарч байга а вm. Манай улсын хувьд ИОТТХ-аар тооцоо хийх ёстой иргэд ОТБТБАИОАТ -ын хуулиар тогтмол татвар өлж байгаа, ИОТТХ -аар тооцоо хийгч иргэдийн дийлэнх нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлт хүссэн иргэд л байдаг гэдэг нь судалгаагаар тогтоогддог. /Ч.Өнөржаргал “ХАОАТ-ын хуульд оруулах санал” илтгэл/

Нөгөө талаар НӨАТ-ын тайлагнал, падаан бүрдүүлэх, шивэх,, тайланг сар бүр бэлтгэж тушаадаг байдал нь татвар өлөгчдөд /орон тооны нягтлан бодогчгүй тохиолдолд бүр ч их/ төвөгтэй, зардал чирэгдэл ихтэй, сэтгэл санааны хувьд дарамттай асуудал болж байгаа нь нийтэд нэгэнт ил байгаа юм. Энэ асуудал нь нийт татварөлөгчдийн дүнд эзлэх НӨАТ төлөгчдийн тоо, хувийн жин харуулж байгаа юм.

Хүснэгт 5. Нийт аж ахуйн нэгжийн ба НӨАТ төлөгчийн тоо

Үзүүлэлт	2010.06.31	2009	2008	2007	2006	2005	2004	2003	2002	2001
Нийт бүртгэл	79,201	74,643	67,282	58,642	52,325	45,774	40110	35,147	30,736	26,231
Нийт ААН тоо	68,673	64,765	58,355	50,416	44,643	38,628	33475	28,800	24,782	20,551
НСАТ төлөгч	12,178	11,820	9,793	7,636	6,138	5,573	5,237	4,699	3,956	3,318
Эзлэх хувь	17.73	18.25	16.78	15.15	13.75	14.43	15.64	16.32	15.96	16.15

График 1. Нийт аж ахуйн нэгж ба НӨАТ төлөгчийн тоог харьцуулсан дүн



Үр ашигтай байх:

Энэ асуудал нв нэг өгрөгний татварын хураахад гарч буй зардлаар хэмжигдэх бөгөөд НӨАТ-ыг харьцангуй цөөн тооны татвар төлөгчдөөс “татвараа өөрөө тодорхойлж төлөх” аргаар ногдуулж хураадаг тул харьцангуйр ашигтай татварын тоонд орох байх. Харин манай улсын хувьд “0” хувиар НӨАТ төлөгчдийн худалдан авсан бараа үйлчилгээнд төлсөн НӨАТ-ыг уг татварыг хураахад зарцуулсан зардлыг бодолцож тооцож хасахгүйгээр олгож байгаа нь зардал гарган байж тайланг хүлээн авч арай гэж цуглуулсан татварынүр ашгийг бууруулах нэг хүчин зүйл болж байгаа нь харагдаж байна.

Зарим судлаачдын дүгнэлтээр буцаан олголт нь цөөн хэдэн хүний ашиг олох бизнес болсон байна. Дараах хүснэгтээс НӨАТ -ын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь ба буцаан олголтыг харж болох юм. Доор НӨАТ -ын орлого ба буцаан олголтын байдалд хийсэн судалгааг харуулав.

Хүснэгт 6. Буцаан олголт ба НӨАТ-ын ДНБ-д эзлэх хувь

д/д	Он	ААН тоо	Сангийн яамнаас буцаан олгосон дүн	2005 оныхтой харьцуулсан хувь
1	2005	46	43461.0	100.0%
2	2006	42	45287.60	104.2%
3	2007	42	49511.70	113.9%
4	2008	128	185091.60	425.9%
5	2009	105	449668.60	1034.6%

Дээрх хүснэгтээс харахад 2005-2007 онуудад буцаан олголт харьцангуй тогтвортой бараг үнийн өсөлтийг авч үзвэл буурсан гэж хэлж болохоор байснаа 2008 ба 2009 онуудад 4-10 дахин өссөн “гажиг” үр дүн гарсан байна. Мэргэжилтнүүдийн тайбарлаж байгаагаар энэ нь нүүрс болон бусад ашигт малтмалын экспорттой холбоотой байгаа юм. Нийт ногдуулсан НӨАТ-тай харцуулбал дийлэнх хувийг нь буцаан олгож байна.

Хүснэгт 7. НӨАТ-ын буцаан олголтын хувь

Үзүүлэлт	2007	2008	2009
Ногдуулсан НӨАТ	143670,0	323880,0	607590,9
Буцаан олгосон НӨАТ	49511.70	185091.60	449668.60
Буцаан олгосон хувь	35%	57%	74%
Цэвэр НӨАТ-ийн орлого	94,158,3	138,788,4	157,992,3

ГУРАВДУГААР ХЭСЭГ: ДУГНЭЛТ, САНАЛ

НӨАТ нь улсын төсвийн орлогыг бүрдүүлж буй гол эх үүсвэр, чухал татвар болох нь дээрх судалгаанаас харагдаж байна. Гэвч дан ганц улсын төсвийн орлогыг бүрдүүлэх гол эх үүсвэр гэдэг утгаар нь авч үзэн хандвал өрөөсгөл болох юм. Иймд НӨАТ-г татварын харилцаанд оролцогч бүх субъектуудийн ашиг сонирхолд нийцэхүйц зөв бүтэц, зөв зохион байгуулалттай зөв систем болгон сайжруулах арга зам, авч болох арга хэмжээг зайлшгүй эрэлхийлэх болж байгаа юм. Иймээс бид дараах үднэлт, саналыг гаргаж байна.

- I. Татварыг энгийн ойлгомжтой, өлөгдөх боломжтой, үр ашигтай байлгахын тулд аж ахуйн нэгж байгууллагууд анх нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлэхдээ дараах байдлаар сонголттойгоор бүртгүүлдэг байх. Үүнд:
 1. Томоохон татвар өлөгч арван хувиар нэмэгдсэн өртгийн албан татвар төлөхдөө худалдан авалтанд өлсөн нэмэгдсэн өртгийн албан татвараа хасуулж, буцаан олголт авна.
 2. Дунд аж ахуйн нэгж нь хялбаршуулсан нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч байж болно. Гэхдээ буцаан олголт авахгүй.
 3. Жижиг аж ахуйн нэгж нь тогтмол нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлж болно. Гэхдээ мөн л буцаан олголт авахгүй, падаан цуглуулахгүй байж болох юм.
- II. Монгол улсын бүх иргэд жилийн туршид худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд төлсөн нэмэгдсэн өртгийн албан татвараа жилд нэг удаа буцаан авах боломжийг олговол татвар өлөгчдийн бааз суурь өсөх боломжтой. Мөн ийм механизмыг хэрэглэснээр НӨАТ-ын үндсэн зорилго болох татвар төлөлтийг татварын хяналт сайжруулах улмаар татварын тогтолцоог боловсронгуй болгоход ихээнхэн ач холбогдолтой юм.
- III. *Татварын шударга тэгш байдал, өлөгдөхүйц байдлыг хангах,* ядуу хэсгийн татварын ачааллыг бага байлгах үднээс хүүхдийн хувцас, ном сэтгүүл, хүнсний бүтээгдэхүүн, цахигаан, дулаан зэрэг өргөн хэрэглээний зарим бараа үйлчилгээнд багасгасан хувийг хэрэглэх.
- IV. Судлаач бидний дэвшүүлсэн жижиг дэлгүүрийн борлуулалтын таамаглал ба бизнес эрхлэгчийн зайлшгүй олох орлогын таамаглалаас харвал өнөөгийн НӨАТ 10 сая

төгрөгийн босго хэт бага байгаа нь хэрэгдэж байна. Бараг бүх ААН, болон хувиараа бизнес эрхлэгчид НӨАТ-ийн хуулийг эрчиж татвар төлөгчөөр бүртгүүлэхгүй байна хэмээн дүгнэж болохоор байна.

- V. Манай орны нийт экспортын дийлэнх буюу бараг 80 орчим хувийг уул уурхайн бүтээгдэхүүн эзлэж байна. Цаашид ч энэ хувь хэмжээ өсөх нь гарцаагүй. Уул уурхайн бүтээгдэхүүнд “0” хувиар татвар ногдуулж байгаа нь бид баялагаа үнэгүйдүүлж /“өртөггүй хэмээн үзэхтэй утга нэг”/ байна гэж шууд ойлгогдохоор байна. Манайх шиг дан уул уурхайгаас хараат улсын хувьд уул уурхайн салбарт арай өөр зарчмаар НӨАТ ноогдуулах /бусад улсаас “хуулахгүйгээр”/ тухайлбал худалдан авалтанд төлсөн НӨАТ-ыг буцаан олгохг өөрөөр хэлбэл чөлөөлөгдөх үйлдвэрлэл үйлчилгээнд хамруулах нь шударга байдалд нийцэх болой.
- VI. Судалгаанаас үзэхэд өндөр хөгжилтэй ихэнх улс экспортоо НӨАТ-аас чөлөөлөх ба “0” хувь хэмжээ хэрэглэдэг ба гэхдээ тэдний эдийн засгийн өнцгөн экспортод чиглэсэн ба гадагш гаргаж байгаа баруун үйлчилгээнүүд нь ихэвчлэн дахин нэмүү өртөг бий болгох боломжгүй буюу эцсийн бүтээгдэхүүн үйлчилгээ байгаа нь манай орноос эрс өөр байгаа юм. Иймээс “0” хувь хэмжээг зөвхөн эцсийн бүтээгдэхүүний экспорт эсвэл дотооддоо цааш дахин боловсруулах боломжг бүтээгдэхүүн үйлчилгээнд ногдуулах нь зүйтэй хэмээн үзэж байна.
- VII. Нийт ДНБ-д эзлэх НӨАТ-ийн хувь хэмжээ өсөх хандлагатай байна. Энэ нь өн л НӨАТ төлөгчийн босго бага байгааг харуулж байна. Бидний саналаар бол ДНБ-д эзлэх хувь буюу НӨАТ -ын ачаалал 3-4 хувьд байгаанөө үед дээр дурдсанчлан зарим бүтээгдэхүүн үйлчилгээний хувь хэмжээг бууруулах, жижиг дунд бизнес эрхлэгчдэд хялбаршуулсан татвар төлөлтийг санал болнох хэрэгтэй байна. Тухайлбал сар бүр НӨАТ-ын тайлан гаргах, НӨАТ-ийн падан үйлдэхгүй байж болох ба тогтмол хэмжээгээр татвар өлөх гэх мэт. Ингэснээр НӨАТ -ын бааз суурь нэмэгдэж, татвараас зайлсхийх явдлыг бууруулах сайн талтай хэмээн үзэж байна.
- VIII. Манай улсын хувьд “0” хувиар НӨАТ төлөгчдийн худалдан авсан бараа үйлчилгээнд төлсөн НӨАТ-ыг уг татварыг хураахад зарцуулсан зардлыг бодолцож тооцож хасахгүйгээр олгож байгаа нь зардал гарган байж тайлангүлээн авч арай гэж цуглуулсан татварын үр ашгийг бууруулах нэг хүчин зүйл болж байгаа нь харагдаж байна. Иймээс “0” хувь хэрэглэж байгаа бол зохих хэмжээний хувь суутган буцаан олгох нь татварын үр ашигт байдалд нийцнэ хэмээн үзэж байна.